

ТАЙВАНЬ ДАХЬ МОНГОЛ СУДЛАЛ

Д. Золбоо

Дэлхий дээрх монгол судлалын салбар тэр тусмаа Монголын Юань гүрний түүх судлал нэлээд өндөр хөгжсөн газрын нэгэнд өнөөгийн Тайвань зүй ёсоор орох бөгөөд 1949 оноос өмнө энэ талын судалгаа огт байгаагүй боловч энд монгол судлаачдын гурваас дөрвөн үе төрөн гарчээ.

Энэ оны 3-р сард Тайваний эрх баригчдын зүгээс Монгол Улсын тусгаар тогтнолыг албан ёсоор хүлээн зөвшөөрч, үндсэн хуулиндаа өөрчлөлт оруулах болсон нь Тайвань дахь монгол судлалын ажил цаашид өргөжин тэлэхэд өөрийн гэсэн тодорхой хувь нэмрээ оруулах нь гарцаагүй юм.

Тайвань дахь Монгол судлалын үндсэн суурь чиглэл нь Юань гүрний түүхийн судалгаа, түүнчлэн Монгол Хятадын харилцаа, XX зууны эхэн үеийн Монголын түүхийн асуудал болон өнөө үеийн Монгол Улсын түүх, соёл, угсаатан, олон улсын харилцаа, улс төр, эдийн засаг, нийгмийн амьдрал зэрэг өргөн салбарыг хамарч байна. Энэ талаар Вань Вэйфань (Wan Weifan), Янь Жямин (Yan Jiaming) "Тайвань дахь сүүлийн 10 жилийн Монгол-Төвд судлал", Лань Мэйхуа (Lan Meihua), "Тайвань дахь Монгол судлалын өнөөгийн байдал", Сяо Чичин (Xiao Qiqing) "Тайвань дахь сүүлийн 40 жилийн Юань улсын түүх судлалын тойм" зэрэг зарим нэгэн эмхтгэл, өгүүлэл ч гарсан байна. Эндхийн Монгол судлаачдын анхдагчид нь Яо Цунвү (Yao Congwu, 1894-1970), Захчид Сэцэн (Цэцэн Жагжид) (Zhaqi Siqin) (Өвөр Монголын Харчин хошуунаас гаралтай Тайваний Их сургууль болон Улс төрийн Их сургуульд ажиллаж байсан нас сүүдэр 87 зооглож яваа энэ буурал Одоо АНУ-ын Калифорн мужийн Сан Хосе хотод энх тунх амьдарч буй ажээ /1/), Сүнь Кекуань (Sun Kekuan) нар гэж үздэг бөгөөд тэдний судалгаа

¹ Д.Золбоо - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

шинжилгээний бүтээлүүдийн энэ салбарт оруулсан хувь нэмэр асар их юм. Сүүлийн хоёр нь өдгөө АНУ, Канадад амьдарч, ажиллаж байна.

Тэдний араас Вань Минсин (Wan Mingxing) Хун Жиньфу (Hong Jinfu), Хуан Чинлянь (Huang Qinglian), Хатанчулуун (Hatun Chilun, 1919-1997), Тань Чи (Tan Qi), Жао Жэньжи (Zhao Zhenji), Дин Куньжянь (Ding Kunjian), Вань Минсунь (Wan Mingsun), Ху Чидэ (Hu Qide), Ли Тяньмин (Li Tianming), Сү Жэньшэнь (Su Zhenshen), Ян Юймэй (Yang Yumei), Жян Ушюн (Jiang Wuxiong) нарын олон тооны эрдэмтэн судлаачид төрөн гарчээ. Мөн эндээс гаралтай одоогоор баруунд ажиллаж байгаа Лю Юаньжу (Liu Yuanzhu, Ohio state University), Пань Байчэн (Pan Baicheng, Wellesley College) нарын зэрэг хүмүүсийг ч мөн нэрлэж болно. /2/

Одоогоор Тайваньд монгол судлалын талаар нэлээд тодорхой ажлууд хийж байгаа газар олон байна. Үүнд, Тайваний ШУА-ийн Орчин үеийн түүх судлалын хүрээлэн, Тайваний Их сургууль, Улс төрийн Их сургууль, Соёлын их сургууль, Хааны ордон музейн дэргэдэх судалгааны хүрээлэн зэргийг нэрлэж болох бөгөөд эдгээр эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэдийн туурвисан эрдэм шинжилгээний чанартай олон тооны ном, нэгэн сэдэвт зохиол, эмхтгэл, өгүүлэл хэвлэгдэн гарч байна.

Одоогоор дээрх байгууллагуудад олон тооны залуу эрдэмтэд монгол судлалын олон салбарт амжилттай сайн ажиллаж байгаа юм. Сүүлийн үед гарсан зарим нэг бүтээлийг дурьдвал, Ляо Шу (Liao Shu), Му Сючэ (Mu Xiuche), Жао Жучэнь (Zhao Zhuchen), профессор Сяо Чичин-ийн "Тайвань дахь сүүлийн 40 жилийн Юань гүрний түүхийн судлалын тойм" (1994), "Монголын Юань гүрний түүхийн шинэ судлал" зэрэг олон ном хэвлэгдэн гарлаа. Ли Юшү (Li Yushu) "Ар Монголын төр шашин хосолсон систем", "Ар Монголын өөртөө засах эрхийг унагасан нь", "Монголын хэргийг шинжлэх нь", Жан Чисюн "Ар Монголын бүрэн эрхт байдлыг буцааж олгох тухай хэлэлцэх нь 1911–1916", "Ар Монголын бүрэн эрхт байдлыг хурааж авах нь 1917–1920" зэрэг номуудыг нэрлэж болно. Мөн Тайваний Улс төрийн

их сургуулийн Угсаатны зүйн тэнхмийн профессор, доктор Лань Мэйхуан сүүлийн үед гаргасан "Гадаад Монгол дахь буриадудын үйл ажиллагаа 1921–1928", "1911 оны Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн" (2000), "Монголд явуулсан Зөвлөлт Оросын улс төрийн бодлого 1917–1924" (2000), "Цэдэнбалын үеийн Монгол–Хятадын харилцаа 1952–1984" (2000) зэрэг зохиол нь ч бас нэлээд сонирхолтой.

Тайваньд зөвхөн 1985–1995 оны хоорондох 10 жилийн дотор нийт монгол судлал түүний дотор угсаатан зүй, соёл судлал болон Монгол улсын талаар нийтдээ 300 /3/ гаруй судалгааны чанартай өгүүлэл, эмхтгэл гарсан байгаа нь чамлахааргүй тоо юм.

Доктор Лань Мэйхуан дээр дурьдсан өгүүлэлд Тайвань дахь Монгол судлалын өнөөгийн байдлын талаар хэлэхдээ "Судлаачдын тоо харьцангуй цөөн байгаа нь судалгааны төвшин зогсонги байдалд орлоо гэсэн үг биш, дунд болон залуу үеийнхэн маань өмнөх судлаачдын өв, бааз сууринд түшиглэн урагшлан хөгжүүлсээр байгаа билээ. Цаг үе өөрчлөгдсөнөөр залуу судлаачдын хувьд өмнөх үеийнхэн шиг тухайн цаг үеийн шаардлагад тулгуурлан үгээ хэлэх шаардлагагүй, харьцангуй бодит объектив шинжтэй судалгаа хийх боломжтой болж байгаа юм. Ахмад судлаачид маань ихэвчлэн мэргэжлийн бус хүмүүс байснаас судалгааны хувьд цэгц муутай, эмх замбараагүй байдал ажиглагдаж байсан. Харин одоогийн судлаачид маань ихэвчлэн мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн, судалгааны хэрэглэгдхүүн, ном товхимол өргөнөөр ашиглах боломж бүрэлдсэн зэрэг давуу талтай. Эдгээрийг сүүлийн үеийн өгүүлэл, нийтлэл зэрэгт тусгалаа олсноос бэлээхэн харж болно. ... Түүнчлэн залуу судлаачдын дийлэнх нь АНУ, Европ, Япон зэрэг газар суралцсан гэдэг утгаараа гадаадын болон Монгол судлаачдын талаарх судалгааны үр дүн, зохиол бүтээлийг өргөн ашиглах, гадаадын эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллах боломж ихтэй хүмүүс юм" хэмээн дүгнэсэн байна.

Мөн Монгол–Төвдийн хороо болон түүний харьяа Монгол–төвдийн соёлын төв ч гэсэн энэ үйлсэд багагүй үүрэг гүйцэтгэж байгааг дурьдах нь зүйтэй юм. Энэ байгууллагын шугамаар хоёр талын

эрдэмтэд санал бодлоо харилцан солилцох болон Тайваний ард түмэнд Монголын түүх, соёл орчин цагийн Монгол орны талаар танилцуулах, сурталчилах үйлсэд тодорхой хувь нэмрээ оруулж байгааг тэмдэглэн хэлэх нь зүйтэй болов уу. Үүний дотор Улаанбаатар хотноо 2000 оны эхээр манай хүрээлэнгээс зохион байгуулсан хоёр талын эрдэмтдийн хамтарсан "Хүрээ-Бээжингийн харилцаа 1911-1919" хэмээх эрдэм шинжилгээний бага хурал ч гэсэн үүний нэгэн баталгаа болсныг тэмдэглэж болох билээ. Уг хурал дээр Тайваний судлаачдын тавьсан илтгэл Монголын түүхэн тухайн үеийн судалгаа энд хэрхэн хөгжсөн болохыг тодорхой хэмжээгээр харуулсан гэж хэлж болох юм. Энэ төвөөс эрхлэн гаргадаг "Монгол Төвдийн найрамдал" сэтгүүлд зарим нэгэн судалгаа шинжилгээ болон олон нийтэд зориулсан эрдэм шинжилгээний хялбаршуулсан маягийн өгүүллийг хятад, монгол хэлээр хэвлэн гаргаж байгаа нь сайшаалтай.

Ойрын жилүүдэд хоёр талын харилцаа эдийн засаг болоод соёл, урлагийн бусад салбарт өргөжин тэлэхийн хэрээр Монгол орныг сонирхох жирийн тайвань иргэдийн тоо нэмэгдсээр байна. Монгол орноор аялсан Жинь Шаошү (Рши Ыхйүчг) зэрэг хүмүүсийн "Диваажингийн тал нутаг", "Гадаад Монголоор аялсан тэмдэглэл" (2000) зэрэг аяны тэмдэглэл хэвлэгдэн гарч уншигчдын хүртээл болжээ. Мөн хятад хэлтэн ард түмний дунд нэр хүнд бүхий зохиолч Ши Мөрөн авгайн хувь нэмрийг ч гэсэн энд дурьдахгүй бол болохгүй бизээ.

Энэ дашрамд сонирхуулахад Тайваньдаа нэр хүнд бүхий танин мэдэхүй, аялал жуулчлалын "МООК" сэтгүүлийн энэ оны 68-рт "Тал нутгийн эзэнт улс – Монгол" гарчигтайгаар өнөөгийн Монгол орны улс төр, эдийн засаг, соёл шинжлэх ухаан болон аялал жуулчлалын талаар тодорхой танилцуулсан, мөн "Дэлхийн газар зүй" сэтгүүлийн 8-р сарын дугаарт Монгол орны баруун хязгаараар аялсан аялагчдын аян замын нийтлэл гарсан байна. Мөн олон улсын харилцаанд гарсан өөрчлөлт тэр дундаа Монгол Улсын газар нутгийг багтаасан дэлхийн газрын зураг гаргах талаар яригдах болсон энэ үед Монгол орныг сурталчлах, ойлгуулах, танилцуулах үйлст Тайваний монголч

эрдэмтэдийн оруулах хувь нэмэр асар их бөгөөд цаашдаа ч улам ихийг хийж бүтээх бизээ.

Энэ товчхон танилцуулгад зарим нэгэн хүний нэр болон бүтээлийн талаар дурьдалгүй орхигдуулсан байж магад бөгөөд дараа дараагийнхаа өгүүлэлд нэг бүрчлэн тодорхой бичих болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. Ш.Баатар, *"Хүн сударын баринтагийг тайлахуй"* Америкийн баруун хойгийн Монголчуудын "Замдаан" сэтгүүл, 2000
<http://www.tsahimurtuu.mn/show.php?table=news&id=5>
2. Лан Мэйхуа, *"Тайваний Монгол судлалын өнөөгийн байдал"*, 2000
3. Ван Вэйфань, Ян Жялин *"Тайвань дахь сүүлийн 10 жилийн Монгол-Төвд судлал"* 1997, Тайбэй, Тайван,
4. Сяо Чичинь, *"Тайвань дахь сүүлийн 40 жилийн Юань улсын түүх судлалын тойм"* 1994, Тайбэй, Тайван